

Энэ илтгэл нь Монгол улсад сүүлийн 20 жилийн туршид бий болж, хуримтлагдсан нийгмийн сөрөг үзэгдлүүд болох авилга, хээл хахууль болон хүнд суртлын шалтгааныг УИХ-ын гишүүдийн “тоо”-той холбон тайлбарлахыг зорилоо.

Анх 76 гэдэг тоог гаргаж ирэхдээ, 1990 оны Ардын Их Хурлын (хувийн өмч гэх зүйлгүй) депутатууд зах зээлийн эдийн засгийн тулгуур хүчин зүйл болох хувийн өмчийн төлөөх өрсөлдөөнийг дутуу үнэлжээ. 76 гэдэг тоо нь энэ өрсөлдөөнийг шударга явагдах нөхцөлийг хангах үүргийг хүлээсэн УИХ-ын гишүүдийн хүчийг хязгаарлаж, улмаар тэднийг авилга, хээл хахуульд автагдах гол хүчин зүйл болсон гэж үзэж байна.

Гишүүдийн эрх мэдэл, нөлөө нийгэмд болоод УИХ-д эзлэх хүчтэй байр суурь, хоорондын холбоо хэлхээ нь далд орлогоо нууж чадах бололцоог бүрдүүлж байна. Эцэстээ, эдгээр төрийн дээд албан тушаалууд нэгэн төрлийн “бизнес” болжээ. Тийм биш бол эдгээр ажлын төлөө өрсөлдөөн ийм их хүчтэй байхгүй байсан. Энэ бизнесийн гол онцлог нь хуулиар тогтоогдсон тооноос олон хүн УИХ-д орж ашгийг нь бууруулж чадахгүйд байгаа юм. Харин энэ бизнес рүү орох эрхийн төлөө хүмүүс нэгэн төрлийн үнэ хаялцах худалдаанд оролцож байна. Энэ нь гишүүн болохын төлөө зарцуулж байгаа эд хөрөнгөөр хэмжигдэж болно. Нэгэнт оруулсан хөрөнгөө ашигтайгаар эргүүлж авахад тэдний нөгөө л эрх мэдэл, нөлөө, нийгэмд болоод УИХ-д эзлэх хүчтэй байр суурь, хоорондын холбоо хэлхээ түлхэц болж байна. Үнэн хэрэгтээ 76 гэсэн тоо нь зарим гишүүдийг хүн чанар, ёс зүйн хэм хэмжээгээ алдахад хүргэж байна. Энэ бол хувь гишүүний буруу биш юм. Харин манай төрийн системийн алдаа, цаашилбал ийм системийг Үндсэн хуулиараа баталгаажуулаад одоог хүртэл хэрэглэсээр байгаа та бидний алдаа гэж дүгнэж болно.

Төрийг бизнес биш болгох нэг арга зам бол УИХ-ын гишүүдийн тоог нэмэгдүүлэхэд оршино. Ингэснээрээ парламентийн нэг суудлын олох ашгийн хэмжээ шууд болон шууд бус замаар буурах нь эргэлзээгүй юм. Шууд бус зам нь олон хүний хоорондох үзэл бодол ашиг сонирхолын зөрчилдөөний үр дүнд мөн тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурь, нөлөө, ач холбогдол буурснаас бий болох юм. Ашиг буурахын хэрээр, нэг суудлын бизнесийн үнэ цэнэ буурч улмаар тэг болж болно. Энэ үед УИХ-д бусадтай адил цалингаараа амьдардаг хүмүүс суух бөгөөд, тэдгээрийн төрийн бусад байгууллагуудад тавих хяналт чангарч, төрийн үйлчилгээний үр ашиг нэмэгдэж, дээр дурьдсан нийгмийн сөрөг үзэгдлүүд устгах болно.

Одоо энэ бодлоо эдийн засгийн онолын нэгэн хялбар загварт оруулан тайлбарлъя.


Энэ эдийн засаг нь маш олон, адилхан хүмүүсээс бүрддэг бөгөөд тэдгээр нь УИХ ба Бусад гэсэн хоёр салбарт хуваагдан ажилладаг гэж үзье. Хүмүүсийн тооны хувьд, УИХ нь Бусад салбартай харьцуулахад маш жижиг. Нэг УИХ-ын гишүүний орлогыг O_G , Бусад салбарт ажилладаг нэг хүний орлогыг O_B гэж тэмдэглэе. Эдгээр орлогуудыг графикын босоо тэнхлэгт тавья. Харин хэвтээ тэнхлэгт хүмүүсийн тоог (T) авъя. Бусад салбараас УИХ-д орохын тулд хүн бүр $X \geq 0$ хэмжээний сонгуулийн зардал төлдөг гэж үзье.

Гишүүдэд эрэлтийг (E_G) ард түмэн үүсгэнэ. Ард түмний орлого тогтмол үед, O_G өндөр бол, цөөхөн гишүүдтэй харин бага бол олон гишүүдтэй УИХ-ыг байгуулж чадна. Ерөнхий тохиолдолд, E_G шугам нь гишүүдийн орлого ба тооны хоорондох сөрөг хамаарлыг харуулна. Бараа үйлчилгээний нийт эрэлт хэрэгцээ Бусад салбарт ажиллах хүмүүсийн эрэлтийг (E_B) тодорхойлно. Эдгээрийн эрэлт хэвийн байх үед, O_B өндөр бол үйлдвэрлэгчид цөөн ажилчинг, харин бага бол олон ажилчинг хөлсөлнө. Эндээс E_B шугам нь энэ салбарын ажилчдын орлого ба тооны хоорондох сөрөг хамаарлыг харуулна. Нийт хүмүүсийн тоог T гэвэл, зах зээлийн тэнцвэр буюу хөдөлмөрийн хуваарилалт салбаруудын хооронд хэрхэн хийгдэхийг харцгаая.


Зах Зээлийн Тэнцвэр нь хоёр салбарт олох “цэвэр” орлого тэнцүү ($O_G - X = O_B$) болж, аль нэг салбарт илүүдэл хүмүүс үүсэхгүй үед тогтоно. Энэ үед бий болох хөдөлмөрийн хуваарилалтыг T_G ба T_B -ээр тэмдэглэе. Мөн $T_G + T_B = T$ нөхцөл бас хангагдах ёстой.

Дээрх нөхцөлөөс бид гишүүдийн болон бусад ажилчдын нийлүүлэлт болох H_T ба H_B хоёрыг гаргаж авна. Хэрэв O_B болон X тогтмол байх үед, O_T өсвөл гишүүн болох сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдэнэ. Үр дүнд нь, $O_T - X = O_B$ нөхцөл хангагдах хүртэл O_T буурч, T_T -г нэмэгдэж, O_B өсөж, T_B буурна. Эндээс H_T шугам нь O_T ба T_T хоёрын эерэг хамаарлыг харуулна. График 1-ийн (а)-д Δ_T болон H_T шугамуудыг дүрслэв. H_T шугам нь, бага тооны хувьд, хэвтээ байгаагийн шалтгаан нь энэ салбар Бусад салбартай харьцуулахад маш жижиг байгаатай холбоотой. O_T жаахан өсөхөд, энэ зах зээл рүү орох хүмүүсийн тоо маш ихээр нэмэгдсэнээр O_T буурч, анхны утгаа авна гэсэн үг. O_T ба X тогтмол үед, O_B өсвөл энэ салбар луу орох хүмүүсийн тоо нэмэгдэнэ. Эндээс нийлүүлэлтийн шугам (H_2) нь орлого ба ажилчдын тооны эерэг хамаарлыг харуулна.

График 1-ийн (б)-д Δ_B болон H_2 шугамуудыг дүрслэв. H_2 шугам нь бүхэлдээ бараг босоо байгаа нь УИХ энэ салбарын маш жижиг хэсэгтэй тэнцүү байгаатай холбоотой.



1990 онд бид анхны Үндсэн Хуулиа баталж УИХ-ын гишүүдийн тоог 76 гэж тогтсон. Ингэснээрээ, бид энэ тоон дээр дахин сонголт хийх хэрэггүй болж, гишүүдийн эрэлт 76 дээр босоо шугам болон үлдсэн – ө.х., $\Delta_T = 76$. График 2-ын (а)-ыг хар. Энэ үеийг анхны тэнцвэр гэж үзье. Өөрөөр хэлбэл, босоо Δ_T шугам H_T -ийг хэвтээ хэсэг дээр нь огтлохдоо $O_T - X = O_B$ нөхцөлийг хангана. Ойлгомжтой болгох үүднээс, тэр үед сонгуульд зардал гаргах шаардлагагүй байсан гэж үзье – ө.х., $X = O$. Үүний мөн чанар доор тодорхой болно. Үндсэндээ энэ нь тэр үеийн улс төрчид шударга байсныг илэрхийлж байгаа юм. Энэ тэнцвэрийг График 2-ын (а) дээр А үсгээр, (б) дээр Б үсгээр тус тус тэмдэглэв. Энэ тэнцвэр дээр $O_{T,1} = O_B$.



Өмч хувьчлал, лицэнз олгох, газар өмчлөл, гадаад худалдаа, төсөл санхүүжилт: 1990 оноос хойш өрнөсөн эдгээр зүйлс нь УИХ-ын гишүүдэд далд орлого олох бололцоог бий болгов. Нэг гишүүний олох дундаж далд орлогыг ДО гэж тэмдэглэе. Гишүүдийн хоорондын зөрчил эсвэл зөвшилцлийн үр дүнд зарим нь үүнээс их, зарим нь үүнээс бага орлого хүртэж болно. Түүнчлэн, нам нь ялсан уу, ялсан бол нэгдэж чадсан уу гэх мэт хүчин зүйлс тухайн гишүүний бодит байдал дээр хүртэж буй далд орлогын хэмжээ тодорхойлогдоно.

Тэгвэл, сонгуулийн өмнө нэг гишүүний ирээдүйд олж болох нийт орлого нь дунджаар $O_{T,1} + ДО = O_{T,2}$. График 2-ын (а)-г хар. Сонгуулийн зардал тогтмол байх үед, гишүүд бусдаас өндөр цэвэр орлого хүлээж байгаа бол (ө.х., $O_{T,2} - X > O_B$), УИХ-д орох сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдэнэ. Үүнийг График 2-ын (а) дээр Д цэг, түүнд харгалзах хүмүүсийн тоог T_2 дүрслэж байна. Гэтэл бидэнд 76 суудал байгаа учир, энэ зах зээл дээр ажилчдын илүүдэл үүсч байна. Энэ тохиолдолд энэ зах зээлийн тэнцвэр ямар хэлбэрээр тогтож байгааг харцгаая.

Тэнцвэрийн тодорхойлолт ёсоор, хүмүүс хоёр салбарт олох “хүлээгдэж байгаа” цэвэр орлого тэнцүү болтол УИХ-д орохоор өрсөлдөх ёстой. Энэ өрсөлдөөн нь нэгэн төрлийн үнэ хаялцуулах худалдаа мэт ажиглагдана – ө.х., сонгуулийн зардлын өсөлт нь хаялцаж байгаа үнийн өсөлтийг илэрхийлнэ. Үнэ хаялцаж худалдаа дараах нөхцөл хангагдах үед зогсоно:

$$O_{T,1} + ДО - X = O_B.$$

Үүнээс X –г олбол

$$X = O_{Г,1} + ДО - O_{Б}$$

УИХ-ийн гишүүдийн шударга орлого нь Бусад салбарын орлоготой дүйцдэг учир (ө.х., $O_{Г,1} = O_{Б}$), дээрх нөхцөлөөс бид дараах үндсэн тэгшитгэлийг гаргаж авна.

$$X = ДО$$


Энэ тэгшитгэлийн дагуу, гишүүн болохын тулд хүн бүр ирээдүйд олох дундаж далд орлоготой тэнцэх хэмжээний мөнгийг сонгуульд зарцуулах ёстой. Жишээлбэл, нэг гишүүн 100 сая төгрөгийг дунджаар олдог бол, энэ хэмжээний мөнгийг сонгуульдаа зарах ёстой. Хэрэв далд орлого олдоггүй бол (ө.х., $ДО = 0$), сонгуулийн зардал тэг болно (ө.х., $X = 0$).

Бодит байдал дээр, УИХ-д орсны дараа зарим гишүүдийн бодит орлого X -ээс бага бол, тэд нэг ёсондоо шатсан гэсэн утгатай юм. Тэдгээр нь магадгүй гишүүдийн цөөнх байж болно. Харин X -ээс их орлого олж байгаа хүмүүс нь гишүүдийн олонх, тэр дундаа холбоо хэлхээ сайтай хүмүүс байж болох юм.

Энэ онол нь манай орны дүр зургийг тодорхой харуулж байна. УИХ-д орох гэж их зардал гаргадаг, орсон хойноо зардлаа нөхдөг. Эндээс үүсэх асуулт бол ямар тохиолдолд УИХ-ын гишүүд шударга ажиллаж, Ог орлогоо хүртэх орчин бүрдэх вэ? Эсвэл яавал $ДО = 0$ болгох вэ?

УИХ-ын гишүүдийн тоог нэмэгдүүлээд үзье. График 2-ын (а) дээр $O_{Г,1}$ КАО $_{Г,2}$ талбай гишүүдийн олох нийт далд орлогын хэмжээ юм. Хэрэв үүнээс их орлого олох боломжгүй гэж үзвэл, нэг гишүүнд ногдох далд орлого шууд буурна. Үүнийг ДО-г бууруулах шууд арга зам гэж нэрлэе. Шууд арга ганцаараа ДО-г тэг болгож чадахгүй. Жишээлбэл, өмнө нь 100 сая төгрөгийг нэг гишүүн дунджаар олдог байсан бол, гишүүдийн тоо 400 болох үед нэг гишүүнд ойролцоогоор 20 сая төгрөг ноогдоно гэсэн үг. 1000 болговол, энэ тоо 7.6 сая болох жишээтэй. Үүнийг цаашид үргэлжлүүлвэл энэ тоо буурахаас биш, яг тэг болохгүй. Гэтэл, гишүүдийн тоо өсөхтэй зэрэгцээд, нэг гишүүний нийгэмд болоод УИХ-д эзлэх байр суурь, ач холбогдол, нөлөө буурна. Ингэснээр далд орлогоо нуух, баригдсан тохиолдолд хэргээ цайруулах зэрэг чадвар суларна. Жишээлбэл, эрхээ түтгэлзүүлэхгүй байхын тулд урьд байснаас олон хүнийг өөртөө татах хэрэгтэй болно. Ингэх нь магадгүй огт боломжгүй зүйл байж болох юм. Энэ нь гишүүдийн далд орлого олох сонирхлыг бууруулах болно. Өөрөөр хэлбэл, бага хэмжээний далд орлого хүртэхийн төлөө үйл ажиллагааны өндөр эрсдэлтэй тулгарна гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр, бага хэмжээний ДО-ын төлөө хүн чанараа алдах сонирхол бас байхгүй байж болно. Ингэж тодорхой хэмжээний далд орлого авахаа татгалзсанаар, зарим гишүүдийн бусдад тавих хяналт сайжирч тэдний хувьд эрсдлийг улам нэмэгдүүлнэ. Үүний үр дүнд, нийт далд орлогын хэмжээ буурч улмаар тэглэж болох юм. Үүнийг шууд бус арга зам гэж нэрлэе.

График 3–т энэ өөрчлөлтийг харуулъя. Эг-ийг баруун тал руу шилжүүлснээр, олон гишүүдийг H_f шугамын дагуу УИХ-д оруулж байна. H_f шугам хэвтээ учир, гишүүдийн шударга орлого $O_{Г}$ -ийг бараг нэмэх шаардлагагүйгээр нэмэлт гишүүдийг оруулж болно. Шууд ба шууд бус арга замын нөлөөгөөр ДО буурсаар тэг болох үед харгалзах гишүүдийн тоог T^* харуулж байна. ДО-ын бууралтыг X -ийн бууралтаар хэмжиж болно.



Олон гишүүдтэй, хэмжээгээр том УИХ-ыг хэрхэн санхүүжүүлэх вэ гэсэн асуулт зүй ёсоор гарч ирнэ. Өнөөгийн УИХ-ын гишүүд хоёроос дөрвөн туслахтай ажиллаж байна. Энэ нь нэг гишүүний хийх ажлын ачаалал их байгааг харуулж байна. Нөгөө талаар энэ туслахуудыг улсын төсвөөс цалинжуулж байгаа. Гишүүдийн тоог нэмэгдүүлж, нэг гишүүний ажлын ачааллыг бууруулж, туслахуудын тоог цөөрүүлэх нь улсын төсөвт дарамт учруулахгүй байх нэг арга юм. Нөгөө талаар, далд орлого олж чадахгүй гишүүд төрийн бусад байгууллагуудад тавих хяналт, шаардлага нэмэгдүүлснээр нийтийг хамарсан авилга хээл хахууль, хүнд сурталыг бууруулж зах зээлийн механизмыг боловсронгуй болгосноор үйлдвэрлэл үйлчилгээ нэмэгдэж татварын орлого шууд ба шууд бус замаар нэмэгдэх бололцоотой юм.